


Эрүүл мэндийн төвийн даргын 2025оны 12 сарын 28-ны
1136 тоот тушаалтын нэгдүгээр хавсралт

БАЯНБУЛАГ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨТӨЛБӨР



1. Хөтөлбөрийн эрх зүйн үндэс

Монгол улсын Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 46.3-т 'төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно" Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.8-д 'эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлогыг тодорхойлон хэрэгжүүлэх' гэж заасан, "АЛСЫН ХАРАА-2050" МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД 2021-2030 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД 2.2.29. Хүн амын хэрэгцээ, тусlamж үйлчилгээний зохион байгуулалт төлөвлөлттэй уялдуулан хүний нөөцийг бэлтгэж, орон нутгийн хэрэгцээг хангаж, эмч, эмнэлгийн ажилтны цалин хөлс, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгсон бодит цалингийн хэмжээг улсын дунджаас дээш байлгана гэж хүний нөөцийн хуваарилалтыг зохистой болгох асуудлууд тусгагдсан нь Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр боловсруулах эрх зүйн үндэс болж байна

2. Хөтөлбөрийн зорилго

Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратеги зорилгыг хэрэгжүүлэх шаардагдах хүний нөөцийн төлөвлөх, бүрдүүлэх, сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх, өнөөгийн хүний нөөцийг үнэлэх ирээдүйн хэрэгцээ тодорхойлох түүнд хүрэхэд учирч болох эрсдэлийг тооцох, гүйцэтгэлд сууринсан бүтээгч байдал, чадварлаг, тогтворт суурьшилтай боловсон хүчин бий болгохын тулд эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны мэдлэг чадварыг дээшлүүлэх удирдах ажилтныг манлайлах ур чадварыг төлөвшүүлэх хөгжүүлэх ажилтан болон удирдах албан тушаалтнуудын харилцаа холбоог бэхжүүлэх ажилтныг давтан мэргэшүүлэх чадавхжуулах ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангахад оршино

2.1. Хөтөлбөрийн зорилтууд

2.1.1. Ажлын байрны хэрэгцээ, шаардлагад нийцсэн чадварлаг, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх

2.1.2. Хүний нөөцийн тогтвортой хөгжлийн хангаж, чадавхын бэхжүүлэх

2.1.3. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах

2.2. Хөтөлбөрийн хамрах хүрээ, хэрэгжүүлэх хугацаа

2.2.1. Эмнэлгийн нийт ажилтнууд хамрагдана

2.2.2. Хөтөлбөрийг 2025-2028 онд хэрэгжүүлнэ

2.3. Хэрэгжүүлэх зарчим

2.3.1. Шударга ил тод, тэгш байдлыг хангах

2.3.2. Авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх

2.3.3. Ажилтан бурийг хамруулах

2.3.4. Хараат бус бие даасан байх

2.3.5. Бодитой, үр дүнтэй байх

2.4. Хөтөлбөрийн санхүүжилт

2.4.1. Хөтөлбөрийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ. Үүнд :

- Эмнэлгийн тухайн жилийн батлагдсан төсөв
- Олон улсын төсөл, хөтөлбөр
- Бусад эх үүсвэр

2.5. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалт

2.5.1. Хөтөлбөрийн ерөнхий удирдлагыг удирдлагын баг, Хүний нөөц хариуцан ажилтан гүйцэтгэж, жил бүр хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тооцож ажиллана

2.5.2. Хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааны зарим хэсгийг гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно

2.6. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг зорилт бүрийн хүрээнд үйл ажиллагаа, түүний хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх хугацаа, хариуцах эзэнд тодорхой тусган эрүүл мэндийн төвийн даргаар батлуулна.

2.7. Хөтөлбөрийн хяналт- шинжилгээ, үнэлгээ

2.7.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт- шинжилгээ, үнэлгээг эмнэлгийн дотоод хяналтын ажилтан, үйлдвэрчний эвлэлийн хороо, ажилтнуудын төлөөллийн оролцоотойгоор хамтран хийнэ

2.7.2. Хөтөлбөрийг түүний хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтийг баримтлан жил тутам дүгнэж харьцуулсан үнэлгээ өгнө

2.7.3. Энэхүү хөтөлбөр болон бусад холбогдох хууль, тогтоомжид заагдаагүй асуудлыг дотоод журамдаа тусгаж хэрэгжүүлнэ

2.7.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд шаардлагатай бол тухай бүрд нь шинэчлэл хийж болно

2.8. Хөтөлбөрийн үр дүн

2.8.1. Эмнэлгийн эрхэм зорилго зорилтыг хэрэгжүүлэхэд хүний нөөцийн оролцоо нэмэгдэж, мэргэжлийн мэдлэг үр чадвартай хүний нөөцөөр хангагдана

2.8.2. Эмнэлгийн хүний нөөц тогтвортой суурьшилтай үр бүтээлтэй ажиллах нөхцөл бүрдэнэ

2.8.3. Энэхүү хөтөлбөр арга хэмжээний төлөвлөгөө хийсэн ажил нь дараагийн хөтөлбөрийг боловсруулах үндэслэл суурь судалгаа болно